

PLITONIT хуурай хөрсжүүлэгч Хөрсжүүлэгч концентрат 1:15



- ✓ 10 литр хүртэлх бэлэн хөрсжүүлэгч гарган авна
- ✓ Дараагийн давхаргын наалдах чадварыг нэмэгдүүлнэ
- ✓ Суурьт 1 үе түрхсэн ч ус шингээлтийг бууруулна
- ✓ Хэрэглээнд хэмнэлттэй
- ✓ Хатахдаа өнгөгүй болдог



МЭРГЭЖИЛТЭН БАЙХ АМАРХАН

Гадна болон дотоод заслын хөрсжүүлэх ажилд зориулсан



Зааврыг өөр хэлээр татах/
Download the manual in another language
kz | az | uz | tj | kg | tm | am | ge | mn

Хэрэглээний хүрээ

PLITONIT Хуурай хөрсжүүлэгч нь дотор болон гадна заслын ажлын өмнө гадаргуугийн тоосжилтыг дарах, ус шингээлтийг бууруулах, зуурмагийн чийгийг хугацаанаас нь өмнө алдагдахаас сэргийлэх зорилготой. Үүнийг цемент, цемент-шохой, гипсэн суурьтай хана, шал, тааз болон гипсэн хавтанг будах, ханын цаас наах, мөн цемент, гипс, полимер суурьтай бүх төрлийн зуурмаг бэлдмэлээр бүрэхийн өмнө гадаргууг бэлтгэх шингэн хөрсжүүлэгч гаргаж авахад ашиглана.

Дараагийн үеийн материалын төрлүүд	Ханын гадаргуу
Хавтан болон керамогранитын (керамо-боржин) цавуу	+
Гипс, цемент эсвэл полимер шавардлага/ чигжээс	+
Цемент, гипс эсвэл холимог цутгадаг шал	+
Эпоксид цутгадаг шал	—
Будаг / Ханын цаас	+
Суурь гадаргуугийн төрлүүд	Ханын гадаргуу
Бетон, төмөр бетон, хөөсөнцөр блок (хөнгөн блок), тоосго, гипс, цемент эсвэл полимер өнгөлөгч шавардлага / чигжээс, гипсэн хавтан (Ховилтой Гипсэн Хавтан), цемент, гипс эсвэл холимог цутгадаг шал	+
Гипсэн хавтан, Шилэн судалтай гипсэн хавтан, Шилэн магнезит хавтан	+
ЦСП (Цементэн зоргодсон хавтан), OSB (Чиглүүлсэн зоргодсон хавтан), фанер (Наамал банз)	—
Сул болон шохойжсон суурь (хуучин шохойжсон шавардлага, 10 МПа-аас бага шахалтын бат бэхтэй бетон суурь болон хагас хуурай тэгшилгээ)	—

Гадаргууг бэлтгэх

Хөрсжүүлэхийн өмнө гадаргууг тоос, шороо, өөх тосноос цэвэрлэнэ. Хуучин болон муу тогтсон сул хэсгүүдийг сайтар арилгах хэрэгтэй.

Ажил гүйцэтгэх дараалал

1	«Бэлтгэх арга» хэсэгт заасны дагуу шингэн хөрсжүүлэгч бэлтгэнэ.
2	Хөрсжүүлэгчийг суурь гадаргуу дээр багс эсвэл өнхрүүшээр (валик) түрхэнэ. Хэвтээ гадаргууг хөрсжүүлэх үед шалбааг (тогтоол ус) үүсэхээс сэргийлнэ үү.
3	Хөрсжүүлэгч түрхсэнээс хойш 120 минут (эсвэл түүнээс дээш) хугацааны дараа суурийн чийг шингээлтийг шалгана, хэрэв суурийн чийг шингээх түвшин хангалттай байвал (хэвтээ гадаргуу дээр дусаасан ус 15 минутаас дээш хугацаанд шингэхгүй байх, эсвэл босоо гадаргуугийн хувьд ус шингэлгүйгээр доош бүрэн урсаж байвал) дараагийн шатны ажилдаа шилжиж болно («Суурийн чийг шингээлтийг хэрхэн шалгах вэ» хэсгийг үзнэ үү).
!	Хэрэв суурь гадаргууд 1 үе хөрсжүүлэгч түрхсэний дараа чийг шингээлт өндөр хэвээр байвал 2 дахь үеийн хөрсжүүлэлтийг хийнэ үү.

Бэлтгэх арга

Шингэн хөрсжүүлэгч бэлтгэхийн тулд PLITONIT Грунтовка сухая (хуурай хөрсжүүлэгч)-ийг устай холих шаардлагатай. Шингэлэх харьцаа нь хүчтэй чийг шингээдэг суурийн хувьд (хийт бетон, хөөсөн бетон, керамзит блок, гипсэн өнгөлөгч шавардлага болон ховилтой гипсэн хавтан г.м.) 1:10 (хөрсжүүлэгчийн нэг жинд – 10 жин ус), харин цементэн суурь, ГКЛ (гипсэн хавтан), ГКЛВ (чийгэнд тэсвэртэй гипсэн хавтан), СМЛ (шилэн магнезит хавтан) -ийн хувьд 1:15 байна.

Хөрсжүүлэгч бэлтгэх ажлыг 600 эрг/мин-ээс ихгүй хурдтай, хошуутай өрөм ашиглан механик аргаар гүйцэтгэнэ.

20–30 секундын турш хутгаад, 5 минут амрааж (тунгаагаад) дахин давтан хутгана.

Бэлтгэсэн хөрсжүүлэгчийг ашиглах хугацаа – ойролцоогоор 240 минут. Хөрсжүүлэгчийг ашиглах хугацааны туршид 60 минут тутамд нэгээс доошгүй удаа механик аргаар үе үе хутгахыг зөвлөж байна.

Суурийн чийг шингээлтийг хэрхэн шалгах вэ

Хэвтээ гадаргууг шалгах	Босоо гадаргууг шалгах
Гадаргууд хөрсжүүлэгчийг түрхсэнээс хойш 120 минут (эсвэл түүнээс дээш) хугацааны дараа суурийн өөр өөр хэсгүүдэд хэд хэдэн дусал ус дусааж шалгана үү.	Шүршигч, багс эсвэл зөөлөн порлон (губка) ашиглан шалнаас дээш ойролцоогоор 1.5 метрийн өндөрт суурь гадаргуу дээр усыг элбэг шүршиж (түрхэж) өгнө үү
Хэрэв дусал ус 20 минутын дотор суурь гадаргууд шингэж байвал хөрсжүүлэгчийг хоёр дахь үеэр дахин түрхэх шаардлагатай	Хэрэв хана дагуу урссан ус суурь гадаргууд бүрэн шингэж байвал хөрсжүүлэгчийг хоёр дахь үеэр дахин түрхэх шаардлагатай
Хэрэв дусаасан ус 20 минутаас дээш хугацаанд суурь гадаргуу дээр тогтож, шингэхгүй байвал дараагийн шатны ажилдаа шилжиж болно.	Хэрэв ус доош урсаж, гадаргууд шингэхгүй байвал дараагийн шатны ажилдаа шилжиж болно

Техникийн үзүүлэлтүүд

Өнгө (хуурай болон шингэлсэн байдалтай)	Цагаан
Түрхсэний дараа суурь гадаргуу дээр үлдэх өнгө	Өнгөгүй
Хатах хугацаа, мин	60-120
1 м ² -ийн зарцуулалт, мл (шингэлсэн хөрсжүүлэгч)	100-200
Усаар шингэлэх харьцаа	Харьцаа
Хүчтэй чийг шингээдэг суурийг (хийт бетон, хөөсөн бетон, керамзит блок, гипсэн өнгөлөгч шавардлага болон ховилтой гипсэн хавтан г.м.) хөрсжүүлэхэд	1:10
Цементэн суурь, ГКЛ (гипсэн хавтан), ГКЛВ (чийгэнд тэсвэртэй гипсэн хавтан), СМЛ (шилэн магнезит хавтан) болон бусад сул чийг шингээдэг суурийг хөрсжүүлэхэд	1:15

Ажлын нөхцөл

Ажлын явцад агаарын болон хөрсжүүлэхэд бэлэн суурийн температур хамгийн багадаа +5 °С байх ёстой. Гаднах ажлыг гүйцэтгэхдээ боловсруулсан гадаргууг хатах хүртэл хур тунадаснаас хамгаалах шаардлагатай.

Анхааруулга

Ажил гүйцэтгэх явцад хөрсжүүлэгчийг үе үе (60 минут тутамд нэгээс доошгүй удаа) хутгахыг зөвлөж байна. Хэрэглэсний дараа багаж, савыг усаар зайлж угаана. Дээр заагдсан шинж чанарууд нь орчны температур (20±2)°С, агаарын харьцангуй чийгшил (60±10)%-д үйлчилнэ. Ажлыг гүйцэтгэхдээ барилгын ерөнхий ажил гүйцэтгэх зааварчилга, барилга угсралтын ажилд мөрдөгдөх аюулгүй ажиллагааны зааварчилга дагаж мөрдөх ёстой. Сул болон шохойжсон суурийг (хуучин шохойжсон шавардлага, 10 МПа-аас бага шахалтын бат бэхтэй бетон суурь болон хагас хуурай тэгшилгээ) хөрсжүүлэхэд PLITONIT Грунт Упрочняющий PROF1-ийг ашиглахыг зөвлөж байна.

Аюулгүй ажиллагаа

Ажил гүйцэтгэхдээ бээлий, нүдний шил, амны хаалт хэрэглээрэй

Зуурмагийг арьс, нүдэнд хүрэхээс зайлсхийгээрэй. Нүдэнд хүргэсэн тохиолдолд нэн даруй их хэмжээний усаар зайлж, эмчид хандана уу.

ХҮҮХДЭЭС ХОЛ БАЙЛГА!

Орц, найрлага

Усанд эргэн уусдаг полимер нунтаг, реологийн үйлдэлтэй нэмэлтүүд, эрдэс дүүргэгч, пигментүүд (будагч бодис)

Тээвэрлэлт ба хадгалалт

Хөрсжүүлэгчийг тухайн тээврийн хэрэгслийн төрөлд мөрдөгдөж буй ачаа тээвэрлэлтийн дүрмийн дагуу бүх төрлийн тээврийн хэрэгслээр тээвэрлэнэ.

Тээвэрлэлтийн явцад бүтээгдэхүүнд агаар мандлын тунадас орохоос бүрэн сэргийлэхийн зэрэгцээ баглаа боодлыг механик гэмтэл болон бүрэн бүтэн байдал алдагдахаас хамгаалсан байх ёстой.

Бүтээгдэхүүнийг чийгтэх, гадна үзэмж алдагдахаас хамгаалсан үйлдвэрлэгчийн баглаа боодолтой нь бүх төрлийн агуулахад, халаах хэрэгслээс 1 метрээс багагүй зайд хадгална. Хадгалах хугацаа: Үйлдвэрийн савлагаатайгаар 12 сар.

Үйлдвэрлэгчийн баталгаа

Хэрэглэгч энэ зааврын тээвэрлэлт, хадгалалтын нөхцөл, энэхүү зааврыг дагаж мөрдсөн тохиолдолд хольц нь Техникийн нөхцөл 2241- 001- 51552155-2013 шаардлагад нийцэж байгааг үйлдвэрлэгч баталгаажуулж байна. Үйлдвэрлэгч нь материалтай ажиллах технологийг дагаж мөрдөхгүй байх, түүнчлэн эдгээр зааварт заагаагүй зорилго, нөхцөлд ашиглах үед хариуцлага хүлээхгүй.

ХЭРЭГЛЭГЧИЙН ТУСЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭ

8 (800) 555 - 71 - 67

[www. plitonit.ru](http://www.plitonit.ru)

e-mail: info@mc-bauchemie.ru